



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/81

Чингис хот

Хуш модны самар бэлтгэлийг
зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.5, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалтууд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2014 оны "Журам батлах тухай" А-166 дугаар, 2020 оны "Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай" А/577 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн ойн сангийн талбайгаас үйлдвэрлэлийн зориулалтаар Хуш модны самар бэлтгэх хэмжээ дууссан, ой хээрийн түймэр гарах эрсдэл нэмэгдэж буйтай холбогдуулан ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар бэлтгэж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн ойн санд нэвтрэхийг хориглосугай.

2. Ойн сангийн талбайгаас Хуш модны самар бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагааг 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон бүрэн зогсоосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллахыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх "Хяналт шалгалт-2020" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Л.Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010239